




Монгол Улсын ногоон эдийн засгийн барометр 2018

Монгол Улс, Улаанбаатар хот, 2018 он
www.greeneconomycoalition.org



Европын холбооноос санхүүжсэн болно





Ногоон эдийн засгийн барометр

Монгол Улс

2018 оны 5 дугаар сар



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Сан бизнес центр 9-р давхар, Ерөнхий сайд Амарын гудамж 29
Улаанбаатар хот, Монгол Улс

Twitter: @UrsulduhChadvar

Facebook: ECRC Mongolia

www.ecrc.mn



Ногоон эдийн засгийн холбоо (Green Economy Coalition)

80-86 Grays Inn Rd, London, WC1X 8NH, United Kingdom

Twitter: @GECoalition

Facebook: GreenEconomyCoalition

www.greeneconomycoalition.org



Энэхүү тайланг Европын холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэв. DCI-ENV/2016/372-847.

Уг тайланд илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Европын холбооны ямар нэгэн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.



Photo: Bayar Balgantseren

Агуулга

Хураангуй: Ногоон эдийн засаг-Алтан боломж	5
Монгол Улсын эдийн засгийн талаарх ерөнхий мэдээлэл	6
Газарзүй	6
Хүн ам	6
Эдийн засаг	7
Монгол Улсад тулгарч буй гол бэрхшээлүүд	9
Хотжилт	9
Агаарын бохирдол	9
Хөрсний доройтол ба цөлжилт	10
Усны хомсдол	10
Шилжилтийн төлөв	11
Олон улсын амлалт ба сурталчилгаа	11
Үндэсний хөтөлбөр болон замын зураглал	11
Аймгуудын оролцоо	12
Ногоон үзүүлэлтүүд	13
Тогтвортой хөгжлийн зорилтуудын индекс	13
Дэлхийн ногоон эдийн засгийн индекс	14
Санхүүгийн системийн шинэтгэл	15
Монгол Улс дахь ногоон санхүүжилт	15
Нийгмийн хөгжил	16
Ногоон салбарууд	16
Ногоон ажлын байр	16
Тэгш бус байдал ба ядуурал	17
Ногоон эдийн засаг руу шилжих нь: Бид хаана явна вэ?	18

Хураангуй

Ногоон эдийн засаг-Алтан боломж

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ) болон Ногоон эдийн засгийн холбоо (НЭЗХ) хамтран ногоон эдийн засаг Монгол Улсад ямар нөлөө үзүүлж болох талаар энэхүү барометрыг хийж гүйцэтгэлээ. Хариуцлагатай хууль эрхзүйн орчин болон тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийг цогцлоон бүрдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтууд нь 2030 он гэхэд өөрчлөхүйц эерэг нөлөө үзүүлэхээр байна. Гэвч Монгол Улс тогтвортой хөгжлийг тууштайгаар бий болгоход бэлэн үү?

ЭЗБӨЧСТ-өөс бэлтгэн гаргасан энэхүү тайланд Монгол Улс тогтвортой хөгжлийн замыг сонгосноор гарч болох зарим эерэг үр дагаваруудыг танилцуулж байна.

Ногоон эдийн засгийг тууштай хөгжүүлснээр түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэлтэй эдийн засгийн хэт савалгааг зогсоох боломжтой билээ. Ногоон эдийн засагт жил бүр хөрөнгө оруулснаар 2030 он гэхэд ажил эрхлэлтийг 5,23%-иар нэмэгдүүлэхийн зэрэгцээ ядуурлын түвшинг 11,6%-иар бууруулах боломжтой юм.

Гэвч Монгол Улс ногоон эдийн засгийг хөгжүүлж энэхүү боломжоо ашиглахад бэлэн байна үү? Европын холбоо, НЭЗХ болон ЭЗБӨЧСТ хамтран гаргасан энэхүү тайлангаар Монгол Улсын ногоон эдийн засаг руу шилжих шилжилтийг тоймлож, өнөөдрийг хүртэл амжилттай хийгдсэн суурь дээрээ тулгуурлан ирээдүйд бий болох боломжуудыг тодорхойлохыг эрмэлзэв.

21-р зууны эхэн хагас дахь уул уурхайн хөгжил Монгол Улсын эдийн засагт огцом өсөлтийг авчирсан.

Сүүлийн жилүүдийн түүхий эдийн үнийн бууралт нь Монгол Улсын эдийн засгийн эмзэг байдлыг харуулж уул уурхайгаас хараат бус солонгорсон эдийн засгийг бий болгох шаардлагатайг дахин санууллаа.

2017 онд Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор Олон Улсын Валютын Сан (ОУВС) ийн “Өргөтгөсөн хөтөлбөрт” хамрагдаж, 5,5 тэрбум америк долларын санхүүжилтийг олон улсын байгууллагууд, хандивлагч орнуудаас авах шугам нээгдсэн.

Ядуурал, тэгш бус байдал, байгаль орчны тулгамдсан асуудлууд, эдийн засгийн эрх чөлөөний хязгаарлагдмал байдал зэрэг асуудлуудыг шийдвэрлэх гарц нь ногоон, хүн болгонд хүртээмжтэй эдийн засгийг бий болгох явдал билээ. Үүнийг бий болгох өргөн боломжууд байгааг энд цохон тэмдэглэх нь зүйтэй.

ЭЗБӨЧСТ-өөс бэлтгэн гаргасан “Монгол Улсын ногоон эдийн засгийн бодлогын дүн шинжилгээний тайлан”-д Т21 загварыг ашиглан дараах таамаглалыг

дэвшүүлсэн юм.

Энэхүү загварын дагуу 2030 он хүртэл жил бүр дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 4%-ийг ногоон хөгжилд хөрөнгө оруулснаар:

- Эдийн засаг тогтвортой өснө;
- 2030 онд ажилгүйдлийн түвшин 2%-аар буурна;
- 2014 онд нэг хүнд ногдох бодит ДНБ 2.1 сая төгрөг байсан бол 2030 онд 3.1 сая төгрөг болно;
- 2014 онд ядуурлын түвшин 21.6% байсан бол 2030 онд 10%-д хүрнэ;
- Нэгж ДНБ дэх хүлэмжийн хий ялгаралтыг 17,2 %-р бууруулна гэсэн дүгнэлт гарсан.

Монгол Улсын ногоон эдийн засаг руу шилжих шилжилт хэрхэн явагдаж байна вэ? Энэхүү шилжилтийн өнөөгийн үйл явц болон цаашид бий болох боломжууд уг тайланд агуулагдсан болно.

“Энэ бүх асуудлуудын гарц нь ногоон, хүн болгонд хүртээмжтэй эдийн засгийг бий болгох явдал билээ.”



Монгол Улсын эдийн засгийн талаарх ерөнхий мэдээлэл

Газарзүй

Монгол Улс нь нийт нутаг дэвсгэрийн хэмжээгээр (1.6 сая км.кв) дэлхийд 18-т, далайд гарцгүй орнуудын дунд 2-т эрэмбэлэгддэг (ОХУ болон БНХАУ-ын дунд байрлах) төв Азийн орон юм.

Байгалийн нөөц баялагаараа дэлхийд 7-рт ордог ба 1170 орчим тогтоогдсон ордууд болон 80 гаруй төрлийн элементийн 10,000 гаруй илэрц тогтоогдсон арвин нөөц баялагтай улс билээ. “Ашигт малтмал, газрын тосны газар”-аас мэдээлснээр нүүрс, зэс, алт, мөнгө болон уран нь хамгийн түгээмэл олддог ашигт малтмал аж.

Монгол Улс нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг уламжлалтай орон. 2016 оны байдлаар Монгол Улсын нийт малын тоо толгой 61.5 саяд хүрсэн байна.

Уур амьсгалын хувьд урт, хүйтэн өвөл болон богино зунтай. Өвөлдөө -40° хүрдэг Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн хүйтэн нийслэл юм. Хахир хүйтэн өвөлтэй ч, Монгол нь Хөх тэнгэрийн орон (жилдээ дунджаар 3000 цаг нартай байдаг) гэдгээрээ дэлхийд танигдсан билээ.

Хүн ам

Монгол Улс ойролцоогоор 3.1 сая хүн амтай (2016 оны байдлаар) ба хүн амын хамгийн сийрэг тархалттай (км. кв тутам 1.8 хүн оногддог) орнуудын нэг боловч хүн амын 52.7% нь

суурьшсан бүсэд амьдардаг. 2016 оны байдлаар нийт хүн амын 46.2% буюу 1.5 сая хүн Улаанбаатар хотод оршин сууж байна.

Үндэсний Статистикийн Хорооны (ҮСХ) гаргасан “Ядуурлын дүр төрх-2016” судалгаагаар 2016 онд ядуурал 8%-аар өсөж, ядууралд нэрвэгдсэн хүний тоо 907,500-д хүрч нийт хүн амын 30 гаруй хувь нь ядуу хэмээх ангилалд багтаж байна. Өөрөөр хэлбэл 100 хүн тутмын 30 нь өдөр тутмын шаардлагатай хоол болон бусад эд зүйлсээ авч чадахгүйд хүрээд байна.¹

1 “Ядуурлын дүр төрх-2016”, ҮСХ

“Өвөлдөө -40° хүрдэг Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн хүйтэн нийслэл юм.”



Хүснэгт 1: Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр

	Улсын дундаж	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
Ядуурлын хамралтын хүрээ	29.6 (0.7)	36.0 (1.4)	33.6 (1.3)	26.8 (1.4)	43.9 (1.7)	24.8 (1.3)
Ядуурлын гүнзгийрэлт	7.7 (0.2)	9.7 (0.5)	8.2 (0.4)	7.0 (0.5)	12.5 (0.7)	6.4 (0.4)
Ядуурлын мэдрэмж	2.9 (0.1)	3.7 (0.2)	2.9 (0.2)	2.7 (0.2)	4.8 (0.3)	2.5 (0.2)
<i>Нэмэлт үзүүлэлтүүд:</i>						
Хүн амын хувь (%)	100.0	13.6	18.4	15.5	7.2	45.2
Хүн ам (мян.хүн)	3 063.6	393.6	585.7	492.0	211.4	1 380.8
Нийт ядуучууд (%)	100.0	16.5	20.9	14.1	10.7	37.8
Ядуучууд (мян.хүн)	907.5	150.1	189.6	127.6	97.1	343.1
Өрхийн ам бүлийн тоо	3.5	3.9	3.3	3.1	3.4	3.6
Хүн ам зүйн ачаалал (%)	41.7	42.8	41.6	41.7	41.3	41.4
Хүүхэд (өрхөд эзлэх хувь)	25.5	27.7	24.1	24.1	25.8	26.0
Өрхийн тэргүүлэгчийн нас	45.7	46.0	46.1	45.7	45.1	45.5
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх	75.2	82.2	77.1	74.6	76.3	72.5
Хотжилт (%)	67.8	33.4	40.8	48.8	41.6	100.0

Санамж: Нийт хүн амын тоо нь засаг захиргааны мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд 2016 оны Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо юм. Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх сурвалж: "Ядуурлын дүр төрх-2016" – УСК, 2017 хуудас 12

Хүснэгт 1-ээс Хангай, Баруун, Зүүн болон Төвийн бүсийн мөн Улаанбаатар хотын ядуурлын түвшинг харж болно. Улаанбаатар болон Төвийн бүсүүдэд ядуурлын түвшин нь хамгийн бага байхад, Зүүн бүсэд ядуурлын түвшин хамгийн их байна.

Эдийн засаг

Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд олон улсын зах зээл дэх түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотойгоор харьцангуй өндөр өсөлттэй байсан хэдий ч 2013 оноос хойш түүхий эдийн үнэ буурсантай холбогдон эдийн засгийн өсөлт удааширсан. График 1-т үзүүлснээр эдийн засгийн өсөлт 2012 онд 17% хүрч байсан бол 2016 онд 1% болж

буурсан байна.

МУЗГ эдийн засаг доройтсон нөхцөл байдалд ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт

хамрагдаж 2017 онд ОУВС болон бусад олон улсын байгууллагууд хандивлагч орнуудаас нийт 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт авах боломж нээгдсэн. ОУВС-ийн



Эх сурвалж: УСК



дэмжлэг болон ирэх жилүүдэд түүхий эд материалын үнэ өсөх хандлагатай байгаа тул Монголын эдийн засаг ойрын жилүүдэд тогтвортой өсөхөөр байгаа бөгөөд эдийн засгийн өсөлтийг дэмжих стратегиудыг хэрэгжүүлэх нь чухал байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын (НҮБ) санхүүжилтээр АНУ-ын Мянганы институт, Монгол Улсын Сангийн Яам болон Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ) хамтран Threshold 21 (Т21) эдийн засгийн загварыг боловсруулсан.

ЭЗБӨЧСТ-өөс гаргасан “Ногоон эдийн засгийн бодлогын дүн шинжилгээний тайлан”-д энэхүү загварыг ашиглан ногоон эдийн засгийн бодлогод тусгагдсан зорилтуудад хүрэх боломж байна уу үгүй юү гэдгийг харьцуулан харсан билээ. Ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжих нь урт хугацааны тогтвортой хөгжилд хүргэнэ хэмээн дараах таамаглалуудаас дүгнэж болохоор байна.

Уг загварын дагуу ДНБ-ийн 4%-ийг ногоон хөгжилд хөрөнгө оруулахад:

- Эдийн засаг тогтвортой өснө;

График 2: ДНБ-ийн өсөлт




График 3: Ядуурал




График 4: Нэгж ДНБ үйлдвэрлэхэд ялгаруулах хүлэмжийн хийн хэмжээ





График 5: Ажилгүйдэл



- Ядуурлын түвшин 2014 онд 21.6% байсан бол 2030 онд 10% болно;
- 2030 онд ажилгүйдлийн түвшин 2%-аар буурна;
- Нэг хүнд ногдох бодит ДНБ 2014 онд 2.1 сая төгрөг байсан бол 2030 онд 3.1 сая төгрөгт хүрнэ;
- Нэгж ДНБ-ийг үйлдвэрлэхэд ялгаруулах хүлэмжийн хийн ялгарал 17,2 % -р буурахаар байна.²

² ЭЗБӨЧСТ (2017), Монголын Ногоон эдийн засгийн бодлогын дүн шинжилгээний тайлан, х.62-64





Монгол Улсад тулгарч буй гол бэрхшээлүүд

Хотжилт

1990 оноос эхлэн хөдөө орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөн эрчимжиж эхэлсэн. 1996 онд Улаанбаатарт оршин суугаа иргэдийн тоо 0.6 сая байсан бол 2016 он гэхэд 1.4 саяд хүрч, 20 жилийн дотор 118%-аар өссөн байна.

Хотод суурьших хүний тоо олшрох тусам замын түгжрэл, агаарын бохирдол болон дэд бүтцийн хомсдол зэрэг асуудлууд бий болсон.

Энэхүү шилжих хөдөлгөөний гол шалтгаан нь орон нутаг дахь ажлын байрны хомсдол болон дэлхийн уур амьсгалын өөрчлөлт юм.

Байгалийн гамшигт үзэгдэл ган, зуд болсон жилүүдэд хөдөө орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөн ихэсдэг.

Сүүлийн 30 жилд суурьшлын бүсийн хүн амын тоо 2 дахин өсчээ.

Агаарын бохирдол

Улаанбаатар хотын жилээс жилд нэмэгдэж буй агаарын бохирдол нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйл болж байна. Ялангуяа бага насны хүүхдийн хэвийн өсөлт, амьсгалын болон зүрх судасны өвчин, дархлааны системийн доголдол, хавдар зэрэг нийт хүн амын эрүүл мэндэд хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна.

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5-ын дундаж түвшин 75 бөгөөд энэ нь ДЭМБ-ын агаарын чанарын стандартаас хэд дахин их үзүүлэлт юм.

Агаарын бохирдлын эх үүсвэрт шороон замын тоос, нүүрсний цахилгаан станц, тээврийн

“Сүүлийн 30 жилд суурьшлын бүсийн хүн амын тоо 2 дахин өсчээ.”





“Монголын тал газар дэлхийн хамгийн том бэлчээрийн экосистемийн нэг юм. Харамсалтай нь энэ систем нь сүүлийн жилүүдэд ихээр доройтсоор байна.

хэрэгслүүдийн утаа ордог ч, гэр хорооллын зуухны утаа хамгийн их нөлөөлдөг байна.

Хөдөө орон нутгаас нүүж ирдэг хүмүүс хотын захын бүсүүдэд гэрээ барьж суурьшдаг бөгөөд гэр хорооллын дэд бүтцийн сүлжээ хангалттай хөгжөөгүйн улмаас тэнд амьдардаг ихэнх хүмүүс цэвэр, бохир ус болон дулааны шугам сүлжээнд холбогдоогүй байдаг.

Өвлийн цагт мянга мянган айл өрхүүд хоол хийж, гэрээ халаахдаа нүүрс, мод болон бусад хаягдлууд түлдэг нь агаарын бохирдол ихсэхэд гол нөлөө үзүүлдэг. Энэ нөхцөл байдал зуны улиралд арай дээрдэж, агаарын бохирдлын хэмжээ буурдаг.

Улаанбаатарын дараа орох Эрдэнэт, Дархан зэрэг томоохон хот, суурин газрууд болон бусад аймгийн төвүүдийн агаарын бохирдлын түвшин Улаанбаатарын адилаар жилээс жилд өсөх хандлагатай байна.

Хөрсний доройтол ба цөлжилт

Монгол Улсын газар нутгийн 77.8 хувь нь цөлжилтийн нөлөөнд автаж, хөрсний доройтолд орох өндөр эрсдэлтэй газар нутгийн хамрах хүрээ 2006 оноос хойш 2-3 хувь өсөж 10 хувьд хүрснийг БОАЖЯ-ны цөлжилтийн атлас-д онцолсон байна. Гэвч уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даац хэтрэх явдал нь хөрсний доройтол ба цөлжилтөд хэрхэн



“Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас Монголын хэдэн зуун нуур, гол горхи ширгэж байна

нөлөөлж байгаа нь одоогоор судлагдаагүй байна.

Усны хомсдол

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас Монголын хэдэн зуун нуур, гол горхи ширгэж, ялангуяа ашигт малтмалын нөөц ихтэй Говийн бүсэд цөлжилт их хэмжээгээр явагдаж байна.

Монгол Улсын гадаргын усны нөөц нь хойд хэсгээрээ төвлөрдөг бөгөөд төвийн болон өмнөд бүсийн хуурай хэсгийг бодвол

ашиглахад хүндрэлтэй байдаг. Азийн Хөгжлийн Банкны 2014 онд нийтэлсэн тайланд Монгол Улс 2010 онд нийт цэвэр усны хэрэглээний 80 хувийг гүний уснаас ашигласан болохыг онцолжээ.

Үүнтэй зэрэгцэн хэрэглээний усны нөөцийн асуудлаас гадна, малын тоо толгойн өсөлт, уул уурхай, хотжилт зэрэг нь усны чанарт хэрхэн нөлөөлж байгаа нь тулгамдсан асуудлууд хэвээр үлдэж байна.



Шилжилтийн төлөв



хөгжлийн байгууллагатай (ДДНХБ) Монгол Улс мөн идэвхитэй хамтран ажилладаг.³

Түүнчлэн ядуурал болон байгаль орчны доройтлыг бууруулах зорилтуудыг үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөрүүдэд оруулах засгийн газрын чармайлтуудыг дэмжиж ажилладаг олон улсын хөтөлбөр⁴ болох НҮБ-ын Ядуурал, байгаль орчны санаачилгатай нягт хамтран ажилладаг.

Үндэсний хөтөлбөр болон замын зураглал

Үндэсний түвшинд МУЗГ ногоон эдийн засгийг дэмжсэн хэд хэдэн эерэг алхамуудыг хийгээд байна.

2014 оны 6 дугаар сард Монгол Улсын УИХ Ногоон хөгжлийн бодлогыг (НХБ) баталсан. Байгаль орчинд ээлтэйгээр эдийн засгаа хөгжүүлэх нь энэхүү бодлогын зорилго юм.

Өнөөдрийг хүртэл НХБ-ын хүрээнд үр дүнгээ өгсөн ажлуудаас дурдвал:

- Нарны болон салхины эрчим хүчээр ажилладаг 41 нэр төрлийн тоног төхөөрөмжийг орлогын албан татвараас чөлөөлж, 21-н

³ ДДНХБ-ын талаар илүү мэдээлэл авахыг [хүсвэл](#)

⁴ Ядуурал, байгаль орчны санаачлагын талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл: <http://www.unpei.org/>

Монгол Улс сүүлийн жилүүдэд дотоодын болон олон улсын түвшинд ногоон эдийн засаг руу шилжихээр идэвхитэй ажиллаж байна.

Олон улсын амлалт ба сурталчилгаа

2016 оны 4 сард Монгол Улс “Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц”-ийн 21 дэх чуулга уулзалтын дараахан Парисын гэрээнд гарын үсэг зурсан.¹ Тус гэрээний дагуу болон “Уур амьсгалын сан (УАС)”-гийн гишүүний хувьд Монгол Улс эрчим

хүчинд хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй бүтээн байгуулалтыг дэмжиж санхүүжүүлэхийг зорин ажиллаж байна.²

2013 онд Монгол Улс ногоон эдийн засагт шилжиж буй орнуудыг дэмжих зорилгоор байгуулагдсан “Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл”-д (НЭЗТТ) нэгдсэн анхны орнуудын нэг болсон.

Хөгжиж буй орнуудын тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих, дэлгэрүүлэх зорилготой байгуулагдсан Даян дэлхийн ногоон

¹ Парисийн гэрээний талаар илүү мэдээлэл авахыг [хүсвэл](#)

² УАС-гийн талаар илүү мэдээлэл авахыг [хүсвэл](#)

“ “ Үндэсний түвшинд Монгол Улсын Засгийн газар ногоон эдийн засгийг дэмжсэн хэд хэдэн эерэг алхамуудыг хийгээд байна.



хуулийн этгээдийн 1 сая ам доллартай дүйцэхүйц татварыг чөлөөлсөн;

- Модны импортод татварын хөнгөлөлт эдлүүлснээр 1,645 га ой модыг устгалаас урьдчилан сэргийлж хамгаалсан;
- БОАЖЯ, Монголбанк, Монголын банкны холбоо (МБХ), болон Нийслэлийн засаг дарга хамтран “Тогтвортой санхүүжилт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үзэг зурсан.⁵

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын (ТХЗ) хүрээнд МУЗГ Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-г (ТХҮБ-2030) 2016 оны 2 дугаар сард баталсан.

ТХҮБ-2030 нь дэлхий даяар ядуурлыг арилгах, байгаль дэлхийг хамгаалах болон хүн бүрийн хөгжлийг дэмжих 17 зорилт бүхий НҮБ-ын ТХЗ-ын бодит хэрэгжилтийн нэг жишээ билээ.⁶ Хүснэгт 2-т Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын чиглэлүүд болон зорилтуудыг тоймлов.

Зарим зорилтуудыг хэмжигдэхүйц тодорхой зааж өгсөн байгаа ч (жишээ нь 2030 оноос өмнө дулааны алдагдлыг 40%-иар бууруулах), зарим нь хэтэрхий ерөнхий (жишээ нь ногоон хотуудын “стандартыг хянах”) тодорхойгүй байна. Одоогийн байдлаар ТХҮБ-2030-ын хэрэгжилтийн үнэлгээ хараахан хийгдээгүй байна.

⁵ http://www.un-page.org/files/public/green_development_policy_of_mongolia_and_its_implementation_t_bulgan_0.pdf

⁶ НҮБ-ын ТХЗ-ын талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл: <http://www.un.org/sustainabledevelopment/sustainable-development-goals/>

Хүснэгт 2 – Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар

Монгол Улсын ТХҮБ-ын хэрэгжилтийн явцыг дараахь 20 үндсэн үзүүлэлтээр тодорхойлж үнэлнэ:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2014 он)	Зорилгот түвшин (2030 он)
1	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	хувь	7,8	6,6
2	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого	Ам.доллар	4166	17500
3	Хүний хөгжлийн үзүүлэлт	Эзлэх байр	90	70
4	Дундаж наслалт	жил	69,57	78
5	Ядуурлын түвшин	хувь	21,6	0
6	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	Эзлэх байр	104	70
7	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	Эзлэх байр	56	40
8	Байгаль орчны багц үзүүлэлт	Эзлэх байр	111	90
9	Эдийн засгийн идэвхитэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал	хувь	84,4	99
10	Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт	оноо	36,5	30,0
11	1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин	промилль	15,1	8
12	100,000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин	промилль	30,6	15
13	Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт (улсын дундаж)	Хүүхдийн тоо	27,3	20
14	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио, цэрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээ	хувь	0	60
15	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ	хувь	78,2	68
16	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	хувь	17,4	30
17	Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо	Сая хүн	0,392	2,0
18	Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрх	хувь	89	10
19	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	17	50
20	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь	хувь	0	100

Photo credit: Muratapa, Flickr

Аймгуудын оролцоо

МУЗГ дээр дурдсан ТХЗ-ыг аймгийн түвшинд хэрэгжүүлэх үе шаттай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж эхлээд байна. НХБ-ын дагуу таван аймгийн төлөөлөл “Ногоон хөгжлийн загвар аймаг” болох сонирхлоо

илэрхийлсэн. Үүний дагуу зарим аймгууд тогтвортой хөгжилд үндэслэн алсын хараагаа тодорхойлж, ногоон хөгжлийн загвар болон ногоон хөгжлийн зарчмуудыг батлаад байна.



Ногоон үзүүлэлтүүд

Тогтвортой хөгжлийн зорилтуудын индекс

Тогтвортой хөгжлийн зорилтуудын (ТХЗ) индексээс НҮБ-ын ТХЗ-ын хэрэгжилт болон бусад орнуудын харьцуулалтыг харж болно. Монгол Улс олон улсын ТХЗ-ын ерөнхий индексээр (157 орноос 95-т эрэмбэлэгдсэн) хөгжиж буй орон гэсэн ангилалдаа багтаж байна. Энэхүү индекс нь Хүний хөгжлийн индекс, субъектив сайн сайхан, нэг хүнд ногдох ДНБ зэрэг бусад хөгжлийн үзүүлэлттэй ойролцоо үр дүнг харуулж байна.

Түүнчлэн Монгол Улсын ерөнхий индексийн үнэлгээ (64.2) нь Зүүн Өмнөд Азийн улс орнуудын дундажтай (63.3) дөхөж байна.

Гэвч эдгээр үзүүлэлтүүд нь зорилт тус бүрийн хэрэгжилтийн зөрүүтэй байдлыг харуулахгүй, ерөнхий үр дүнг харуулж байгаа нь дутагдалтай

юм. Монгол Улс ТХЗ-ын 1, 4 болон 10 дугаар зорилтуудын (“Ядуурлыг арилгах”, “Боловсролын чанарыг нэмэгдүүлэх” болон “Тэгш бус байдлыг бууруулах”) хүрээнд 75-аас дээш оноотой буюу харьцангуй сайн үр дүн харуулж байгаа ч, ихэнх зорилтуудын хэрэгжилтэд засаж сайжруулах зүйлс олон байна.

Бодит байдал дээр, Монгол Улсын 17-н зорилтоос 8 нь улаанаар тэмдэглэгдсэн байдаг нь одоо байгаа нөхцөл байдлыг засаж сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Ялангуяа Монгол Улсын хувьд ТХЗ-ын 2, 7 болон 9 дүгээр

зорилтуудын (“Өлсгөлөнг зогсоох”, “Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх” болон “Үйлдвэрлэл, инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх”) хэрэгжилт нь 50 хувьд ч хүрээгүй байгаа нь тулгамдаж буй асуудлуудын нэг болж байгаа юм.

Дэд бүтэц, эрчим хүч болон инноваци нь өртөг ихтэй, урт хугацааны хөрөнгө оруулалт шаардлагатай байдаг тул эдгээр зорилтуудад хүрэхэд стратегийн нарийн төлөвлөлт шаардлагатай.

Мөн эдгээр салбарууд нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын гол цөм учир яаралтай шийдвэрлэх нь зүйтэй юм.

“Монгол Улс ерөнхий үзүүлэлтээр харьцангуй сайн үр дүнтэй байгаа ч, ихэнх зорилтуудын хэрэгжилтэд засаж сайжруулах зүйлс олон байна.



Photo: European Bank of Reconstruction and Development, Flickr



“ Монгол Улсыг ДНЭЗИ-ээр үнэлэхэд нийт 80 орноос 79-т эрэмбэлэгдсэн тааруу үзүүлэлттэй байна.”

Дэлхийн ногоон эдийн засгийн индекс

Дэлхийн ногоон эдийн засгийн индекс (ДНЭЗИ) нь улс орнуудын ногоон эдийн засгийн үзүүлэлт, үйл ажиллагааг хэмжиж дүгнэдэг. Энэхүү индекс нь нийт 80 улс орныг ногоон эдийн засаг руу хэрхэн шилжиж байгааг хэмжиж, харьцуулах боломжийг олгодог.

2016 онд Монгол Улсыг ДНЭЗИ-ээр үнэлэхэд нийт 80 орноос 79-т эрэмбэлэгдсэн тааруу үзүүлэлттэй байв.

Гэсэн хэдий ч, Монгол Улсын ДНЭЗИ дэх үзүүлэлт болгон тааруу, муу гэсэн үг биш. Жишээ нь ерөнхий үзүүлэлт тааруу ч

“Манлайлал ба цаг уурын өөрчлөлт” гэсэн зорилтын хэрэгжилт “Сайн” гэж дүгнэгдсэн.

МУЗГ-аас хэрэгжүүлж буй ногоон хөгжлийн бодлогууд болон Монгол Улсын олон улс дахь тогтвортой хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа нь “Сайн” хэмээн үнэлгээ авахад гол нөлөө үзүүлжээ.

Мөн “Байгаль орчин” гэсэн үзүүлэлтийн үнэлгээ нь “Зах зээл ба хөрөнгө оруулалт” болон “Үр ашигтай салбар” гэсэн хоёр үнэлгээний үр дүнтэй харьцуулахад тийм ч бага байсангүй. Монгол Улсын ногоон эдийн засаг руу шилжих шилжилтэд тулгамдаж буй асуудал дээрх хоёр үнэлгээнээс харагдаж байна.

Түүнчлэн амлалт болон хэрэгжилтийн хооронд байгаа зөрүү нь гол бэрхшээл болоод байна.



“ Амлалт болон хэрэгжилтийн хооронд байгаа зөрүү нь гол сорилт болоод байна.”

Жишээ нь Монголчуудын “ойлголцол”-ын индекс нь ерөнхий индексээс 12 эрэмбээр дээгүүр (67-д) байгаа юм.

МУЗГ-ын хичээл зүтгэл тодорхой хэмжээнд олон улсын түвшинд ч гэсэн анхаарал татаж чадаж байна.

Засгийн газрын бодлогуудыг тодорхой ажил хэрэг болгох мөн бодит үр дүн гаргах чармайлтууд нь Монгол Улсыг ногоон эдийн засаг руу шилжих явцад чухал үүрэг гүйцэтгэх билээ.

Санхүүгийн системийн шинэтгэл

Монгол Улсын ногоон санхүүжилт

Монгол Улс тогтвортой, ногоон эдийн засаг руу шилжихэд асар их хэмжээний хөрөнгө оруулалт хэрэгцээтэй байна. МБХ-ны үзэж байгаагаар эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч, барилга, хог хаягдал болон тээврийн салбарт чиглэсэн үндэсний төслүүдийг бүрэн санхүүжүүлэхэд 7 тэрбум ам.доллар шаардлагатай. Мөн түүнчлэн 4.3 тэрбум ам.доллар агаарын болон хөрсний бохирдолтой тэмцэхэд хэрэгтэй байна.

Монголын санхүүгийн салбарын ногоон эдийн засаг руу чиглэсэн үйл ажиллагаа хязгаарлагдмал хэмжээнд байдаг. График 6-аас харахад

Монголын санхүүгийн салбар ногоон эдийн засаг руу шилжих шилжилтийг дэмжиж, хамтран ажиллаж байгаа.

байгалийн нөөцийг хамгаалах болон нөхөн сэргээхэд зарцуулсан сүүлийн таван жилийн хөрөнгө оруулалт тогтворгүй байна. 2015 он хүртэл гурван жилд хөрөнгө оруулалт 26%-аар өссөн хэдий ч, 2016 онд 13%-аар буурсан байна. Энэ нь Монголын эдийн засгийн хөгжилтэй шууд холбоотой бөгөөд эдийн засгийн өсөлт буурах тохиолдолд ийм төрлийн хөрөнгө оруулалт багасдаг гэдгийг харж болно.

Хэдийгээр Монголын санхүүгийн салбарын ногоон эдийн засаг

руу чиглэсэн үйл ажиллагаа хязгаарлагдмал боловч огт байхгүй гэсэн үг биш юм. Үүний нэг жишээ нь Монголын Тогтвортой санхүүжилтийн форум (ТоС) билээ.

Энэхүү форумыг 2013 оноос жил бүр Монгол Улсад ногоон эдийн засгийг хөгжүүлэх, хамтран ажиллах талаар Засгийн Газрын гол агентлагууд, салбарын манлайлагчид санхүүгийн байгууллагууд зохион байгуулдаг болсон.


Хэрэгжүүлж эхэлсэн хэд хэдэн санаачилгуудаас харахад ногоон болон тогтвортой хөгжил рүү чиглэсэн зарим төслүүдэд тодорхой хэмжээний санхүүжилт олгогдож эхэлсэн байна. Тухайлбал 2016 оны 12 дугаар сард ХасБанк УАС-тай магадлан

итгэмжлэлийн гэрээ байгуулсан. 2017 оны 7 дугаар сард Монголын бичил болон ЖДҮ-ийн нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах санаачилгуудыг дэмжих 60 сая ам долларын төслийн 20 сая ам долларыг ХасБанк-д шилжүүлсэн байна.

2017 оны ТоС Форумын үеэр Монгол Улсад ногоон зээлийн сан байгуулах тухай мэдэгдсэн нь бас нэгэн сайхан мэдээ байлаа. Энэхүү сан нь уур амьсгалын өөрчлөлт рүү чиглэсэн анхны санхүүгийн хөшүүрэг болж байгаа бөгөөд ДДНХБ хамтран ажиллах юм.

Үйл ажиллагаа эхлэх үед, Улаанбаатар хот дахь барилгуудыг эрчим хүч хэмнэлттэй болгох төслүүдийг санхүүжүүлэхээр 8-10 сая ам доллар зарцуулах төлөвлөгөөтэй байна. Эдгээр санаачилгууд нийгэмд хэрэгтэй төдийгүй цаашид өргөжүүлэх шаардлагатай. Монгол орны ногоон эдийн засаг руу шилжих шилжилтэд санхүүгийн урсгалыг нэмэгдүүлэх нь нэн тэргүүний асуудал хэвээр байна.

График 6 – Байгалийн нөөцүүдийг хамгаалах, нөхөн сэргээхэд хөрөнгө оруулсан байдал



Эх үүсвэр: www.1212.mn, ЭЗБӨЧСТ-ийн шинжилгээ Ам долларын ханшийг 2016 оны үнээр тогтмол авч ашиглав



Нийгмийн хөгжил

Хүснэгт 3 – Эдийн засгийн гол салбаруудын өнөөгийн нөхцөл байдал

Хөдөө аж ахуй	Уул уурхай	Эрчим хүч
Монгол Улсын эдийн засгийн чухал салбарууд болох хөдөө аж ахуй болон уул уурхайн салбарын бодлогын тогтолцоог сайжруулах хэрэгтэй. Нийт бэлчээрийн 70 орчим хувьд нь хөрсний доройтол ажиглагдаж байна. Ноолуур нь олон хүний амьжиргааны эх үүсвэр болдог хэдий ч тухайн салбар нь байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй байна. Иймээс хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах арга хэмжээ дутмаг байна.	ТХҮБ 2030-ын зорилгуудын нэг нь ил тод, өрсөлдөх чадвартай уул уурхайг дэмжих явдал юм. 2016 онд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд байгаль орчны хамгаалалд зөвхөн нэг сая ам доллар зарцуулсан. Нөхөн сэргээлтийн ажлууд хангалтгүй хийгдэж байна. Монгол Улсын эдийн засгийн хөгжилд чухал нөлөөтэй энэхүү салбарт бодитой сайжруулалт хийгдэх шаардлагатай.	Одоогийн байдлаар Монгол Улсын нийт эрчим хүчний 7%-ийг сэргээгдэх эрчим хүч хангаж байна. ТХҮБ 2030-ын дагуу сэргээгдэх эрчим хүчийг 30%-д хүргэх зорилго тавьсан байна. Сүүлийн үед хэрэгжүүлсэн төслүүд: Цэцийгийн 50-н мегаваттын (2017), Сайншандын 120-н мегаваттын (2016), Салхитын 50-н мегаваттын (2013) салхин цахилгаан станц МУЗГ сэргээгдэх эрчим хүчинд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн импортын татаварыг хөнгөлсөн.

Ногоон салбарууд

Монгол Улсын эдийн засгийн гол салбаруудад засаж сайжруулах хэд хэдэн асуудлууд байна. Хөдөө аж ахуй, уул уурхай болон эрчим хүчний салбарууд дахь нөхцөл байдлыг хүснэгт 3-аас харна уу.

Ногоон ажлын байр

Монгол Улсын НХБ-ын зургаан стратегийн зорилтуудын нэг нь ногоон ажлын байр бий болгох явдал юм. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) ногоон ажлын байрны тодорхойлолтод нийгмийн хариуцлага, зохистой цалин хөлсийг нь төлөх, нийгмийн хамгаалал болон байгаль орчны тогтвортой байдал гэсэн ойлголтууд хамрагддаг.

ЭЗБӨЧСТ нь 2014 онд НЭЗТТ-ийн хүрээнд ОУХБ, БОАЖА-ы захиалгаар ногоон ажлын байрны зураглал судалгааг хийж гүйцэтгэсэн. Тус судалгааг НҮБ болон бусад оролцогч талууд эерэгээр хүлээн авсан. Энэхүү судалгаагаар ногоон ажлын байрны тоог тооцолж, тэдгээрийг эдийн засгийн салбарууд, дэд салбарууд болон газарзүйн байршлаар нь тодорхойлсон. Үүнээс гадна зарим салбарууд дахь зохисгүй хөдөлмөр эрхлэлтийг тогтоосон.

2017 онд ҮСХ, ОУХБ болон НЭЗТТ хамтран Монголд анх удаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу Монгол Улсын байгаль орчны салбарын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрны түршилт судалгааг хийж гүйцэтгэсэн.

Тус судалгаагаар 2016 оны хоёрдугаар улирлын байдлаар Монгол Улс дахь ногоон ажлын байрны тоо 112.3 мянгад хүрч, нийт ажлын байрны 9.9%-ыг эзэлж байв.

“ 2016 оны хоёрдугаар улирлын байдлаар Монгол Улс дахь ногоон ажлын байрны тоо 112.3 мянгад хүрч, нийт ажлын байрны 9.9%-ыг эзэлж байв.”




Хэдийгээр ийм судалгаа өмнө хийгдэж байгаагүй ч, судлаачдын ашигласан аргачлал нь ирээдүйн үнэлгээнүүдийн суурийг тавьж өгсөн. Ногоон ажлын байрны чиг хандлага нь Монголын ногоон эдийн засагт шилжих шилжилтийг илүү өргөн хүрээнд авч хэлэлцэх боломжийг олгож байгаа юм.

Тус судалгаанд Монгол Улсын эдийн засгийн салбаруудад ногоон ажлын байруудын тоо хэмжээний талаарх хэрэгцээтэй мэдээлэл агуулагдсан. Судалгааны үр дүнгээс харахад нийт ногоон ажлын байрны 30.3% нь боловсролын, 15.9% нь аж үйлдвэр, 9.4% нь уул уурхай мөн 6.2% нь удирдлагын салбарт байна. Хэдийгээр боловсролын салбар нь ирээдүйн хөрөнгө оруулалт ч гэлээ, байгаль орчны (болон нийгмийн) тогтвортой байдалд нэн тэргүүнд хэрэгцээтэй ногоон ажлын байрны тоог нэмэх нь чухал билээ.

Тэгш бус байдал ба ядуурал

1990-ээд онд зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа, зарим статистикийн үзүүлэлтүүдээс

Хүснэгт 4: Монгол Улсын тогтвортой хөгжлийн идэвхжилт



(ЖИНИ индекс, тэгш бус байдлыг оруулсан Хүний хөгжлийн индекс, Палма харьцаа) дүгнэлт хийхэд Монгол Улсын орлогын тэгш байдал харьцангуй сайн байсан. 2014 он хүртэл Монголын Улсын ядуурлын түвшин буурч, хүн амын багагүй хэсэг нь ядуурлаас гарсан сайн үр дүнг харуулсан. Гэвч 2014 оноос эдийн засгийн өсөлт саарснаар ядуурал нэмэгдсэнийг сүүлийн үеийн тоо баримтуудаас харж болно.

Ихэнх хөгжиж буй орнуудтай харьцуулахад сүүлийн 25 жилд Монголын нийгэмд тэгш бус байдал эрс нэмэгдээгүй ч ядуурлын түвшин буурах хандлагатай байна.

Гэсэн хэдий ч түүхий эдийн экспортоос хэт хараат байгаа нь аймаг хоорондын эдийн засгийн хөгжлийн ялгааг бий болгосон. Уул уурхай хөгжсөн Орхон аймгийн эдийн засгийн хөгжил илүү хурдацтай явагдаж байна.

“Ногоон өсөлт” стратегийн хүрээнд эдийн засгийн өсөлт болон нийгмийн хүртээмжтэй байдлыг хангах үүднээс ирэх жилүүдэд дээр дурдсан газарзүйн ялгааг бууруулахын тулд эдийн засгийг төрөлжүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулах хэрэгтэй.





Ногоон эдийн засаг руу шилжих нь: Бид хаана явна вэ?

Энэхүү тайланд дурдагдсан ногоон эдийн засаг руу шилжих шилжилтийн ололт амжилт болон бэрхшээлүүдийг нэгтгэн дүгнэж, НЭЗХ-оос Монгол Улсын ногоон эдийн засаг руу шилжих үйл явцыг 10-аас 3 оноогоор дүгнэж байна.

Монгол Улс нь цаасан дээрх хууль тогтоомж болон түүний хэрэгжилтийн хооронд асар их ялгаатай байдгийн тод жишээ билээ. Шинэ бодлого, хуулиуд, олон улсын санал санаачилгуудад идэвхитэй оролцох нь шилжилтийн үед чухал байдаг ч дангаараа хангалтгүй юм.

2016 онд ДНЭЗИ-ийн үнэлгээгээр Монгол Улс нийт 80 орноос 79-т эрэмбэлэгдсэн тааруу үзүүлэлт гаргасан. Түүнчлэн 2015 оны НҮБ-ын байгаль орчны хөтөлбөрийн “Ногоон эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт”-ээр Монгол Улс хүртээмжтэй ногоон эдийн засгийн хөгжлийн замаас ухарч буй үр дүнг үзүүлжээ.

Хэдийгээр Монгол улсын ТХЗ-ын хэрэгжилт Зүүн өмнөд Азийн орнуудын дундажтай ойролцоо байгаа ч, нийт 17 зорилтын тэн хагас нь улаанаар тэмдэглэгдсэн байна. Ялангуяа 2,7,9-р зорилтууд (Өлсгөлөнг зогсоох, Сэргээгдэх эрчим хүчийг сайжруулах, Инноваци, дэд бүтцийг хөгжүүлэх) хамгийн сул үр дүнтэй байгаа юм.

Ногоон эдийн засаг руу шилжих шилжилтийг үр дүнтэй, хурдан явуулахын тулд хувийн хэвшил, иргэний нийгэм, засгийн газрын



“ЭНЭХҮҮ ТАЙЛАНД ДУРДАГДСАН НОГООН ЭДИЙН ЗАСАГ РУУ ШИЛЖИХ ШИЛЖИЛТИЙН ОЛОЛТ АМЖИЛТ БОЛОН БЭРХШЭЭЛҮҮДИЙГ НЭГТГЭН ДҮГНЭЖ, МОНГОЛ УЛСЫН НОГООН ЭДИЙН ЗАСАГ РУУ ШИЛЖИХ ҮЙЛ ЯВЦЫГ 10-ААС 3 ОНООГООР ДҮГНЭЖ БАЙНА.

агентлагууд, болон олон нийтийн оролцоо, ойлголцол, түүштай байдал чухал билээ. Аз болоход ногоон ажлын байр, агаарын бохирдол зэрэг зарим нэг асуудлууд олон нийтийн анхаарлын төвд орж чадсан байна.

ТХҮБ-2030, НХБ зэрэг бодлогын түвшний санал, санаачилгын ачаар шинэ санаачилгууд болон инновациуд гарч ирсээр байна. Гэсэн хэдий ч энэ

үйл явцыг хурдасгах шаардлагатай байгаа юм.

Аж үйлдвэрийн дарамтаас болж Монголчуудын байгалийн өв хурдацтайгаар доройтож байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн замыг сонгохгүй бол өнөөдрийн эдийн засгийн болон нийгмийн ололт амжилт эрсдэлд орох аюултай тулгараад байна.

**Нэр томъёоны товчлол**

БОАЖЯ	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
ДДНХБ	Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДНЭЗИ	Дэлхийн ногоон эдийн засгийн индекс
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
МБХ	Монголын банкны холбоо
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НХБ	Ногоон хөгжлийн бодлого
НЭЗТТ	Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл
НЭЗХ	Ногоон Эдийн Засгийн Холбоо
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ТоС	Тогтвортой санхүүжилт
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТХҮБ	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
УАС	Уур Амьсгалын Сан
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Сан бизнес центр 9-р давхар, Ерөнхий сайд Амарын гудамж 29,
Улаанбаатар хот, Монгол Улс

Twitter: @UrsulduhChadvar

Facebook: ECRC Mongolia

www.ecrc.mn



Green Economy Coalition

80-86 Grays Inn Rd, London, WC1X 8NH, United Kingdom

Twitter: @GECoalition

Facebook: GreenEconomyCoalition

www.greeneconomycoalition.org